



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/165

Улаанбаатар хот

Насан туршийн суралцахуйн төвийн
бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2, 31.1.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэний албан, албан бус сургалтаар боловсрол эзэмших, бие даан суралцахад мэдээллээр ханган, зөвлөн туслах, удирдан зохион байгуулах “Насан туршийн суралцахуйн төв”-ийн бүтэц орон тоог шинэчлэн баталсугай.

2.Насан туршийн суралцахуйн төвийн бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

3.Тус төвийг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлж ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа) нарт үүрэг болгосугай.

4.Төвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хөрөнгийг орон нутгийн төсөвт тусгаж батлуулахыг Санхүү, Төрийн сангийн хэлтэс (Ц.Мягмарсүрэн)-т даалгасугай.


5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2014 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/124 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны ...07 дүгээр сарын ...31... ны өдрийн
АА65 дугаар захирамжийн хавсралт



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН
ТӨВИЙН БҮТЭЦ, ОРОН ТОО

Д/д	Албан тушаалын нэрс	Орон тоо
1	Захирал	1
2	Сургалтын менежер	1
3	Нягтлан бодогч	1
4	Нярав, бичиг хэрэг	1
5	Үйлчлэгч	1
6	Гэр бүл, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт хариуцсан багш	1
7	Иргэний эрх зүй, улс төрийн боловсрол олгох сургалтын багш	1
8	Харилцаа, ёс зүйн боловсрол олгох сургалтын багш	1
9	Амьдрах ухаан, санхүүгийн боловсрол олгох сургалт хариуцсан багш	1
10	Соёл, гоо зүйн боловсрол олгох сургалт хариуцсан багш	1
11	Боловсрол нөхөн олгох сургалт хариуцсан багш	1
12	Бичиг үсгийн боловсрол хариуцсан багш	1
НИЙТ		12